

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/048/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор: С.Төмөрхуяг

Утас: 7058-4207, Цахим хаяг: tumurkhuyags@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-9
3. Аудитын илрүүлэлт	10
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	11

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БЧШ	Боловсролын чанарын шинэчлэл
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2026.02.24 № 71.

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ
Л.ХИШИГТОГТОХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Боловсролын ерөнхий газраас 94.7 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,863,572,869.23	2,080,360,877.15
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	660,577,253.44	691,955,458.36
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	660,577,253.44	691,955,458.36
3121	Төгрөг	660,577,253.44	691,955,458.36
31211	Төрийн сангийн харилцах	645,132,485.59	691,955,458.36
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	15,444,767.85	-
33	АВЛАГА	25,335,807.00	8,360,400.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	46,807.00	-
335	Бусад авлага	25,289,000.00	8,360,400.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	25,289,000.00	8,360,400.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,177,659,808.79	1,380,045,018.79
351	Түүхий эд материал	686,351,721.69	736,906,971.69
35110	Тусгай зориулалттай материал	686,351,721.69	736,906,971.69
354	Хангамжийн материал	435,618,087.10	580,113,047.10
35410	Бичиг хэргийн материал	1,265,000.00	1,370,000.00
35420	Аж ахуйн материал	361,711,826.10	478,971,486.10
35430	Сэлбэг хэрэгсэл	1,727,000.00	2,327,000.00
35450	Барилгын засварын материал	7,142,700.00	24,869,500.00
35470	Бусад хангамжийн материал	63,771,561.00	72,575,061.00
35600	Мал амьтад	55,690,000.00	63,025,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,817,061,940.70	10,275,153,059.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,817,061,940.70	10,275,153,059.95
392	Биет хөрөнгө	8,881,801,108.70	8,339,959,727.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,641,915,061.00	9,604,544,776.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,632,602,351.58)	(2,924,809,580.33)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	619,633,543.00	619,633,543.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(388,574,102.41)	(416,917,024.63)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,268,885,733.40	3,696,727,764.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,641,626,886.66)	(3,175,734,594.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	295,741,967.93	236,445,988.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	(224,183,351.14)	(173,801,276.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	949,818,176.00	949,818,176.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(94,981,817.64)	(166,218,180.87)
39217	Ном	87,775,136.80	90,270,136.80
393	Биет бус хөрөнгө	1,935,260,832.00	1,935,193,332.00
39301	Програм хангамж	38,251,535.00	18,405,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(37,981,535.00)	(18,202,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,934,990,832.00	1,934,990,832.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,680,634,809.93	12,355,513,937.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,680,634,809.93	12,355,513,937.10
51	Засгийн газрын хувь оролцоо	12,680,634,809.93	12,355,513,937.10
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГС/ орон нутгийн сан	5,244,182,833.00	5,244,182,833.00
51101	Өмч: - төрийн	5,244,182,833.00	5,244,182,833.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,556,843,894.78	3,231,723,021.95
51210	Өмнөх үеийн үр дүн	3,556,843,894.78	3,554,118,894.78
51220	Тайлант үеийн үр дүн	-	(322,395,872.83)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,879,608,082.15	3,879,608,082.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,680,634,809.93	12,355,513,937.10

Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	19,434,455,263.30	6,703,558,070.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,143,826,261.09	68,973,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,143,826,261.09	68,973,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,917,982,560.10	29,200,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	133,380,585.46	-
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	200,532,735.67	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/	11,584,069,238.97	29,200,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/	1,225,843,700.99	39,773,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,290,629,002.21	6,634,585,070.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,587,786,600.00	6,073,979,478.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,587,786,600.00	6,073,979,478.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	309,779,702.21	218,261,292.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	191,487,699.36	218,261,292.00
131107	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	118,292,002.85	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	393,062,700.00	342,344,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	393,062,700.00	342,344,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,753,820,453.37	7,025,953,942.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,753,820,453.37	7,025,953,942.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,286,241,882.12	6,726,503,665.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,608,933,519.00	4,210,617,105.16
210101	Үндсэн цалин	2,194,320,549.00	2,447,221,329.00
210102	Нэмэгдэл	1,035,751,740.30	1,376,164,695.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	155,642,199.00	158,875,000.00
210104	Урамшуулал	223,219,030.70	228,356,081.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	442,414,320.99	520,560,071.28
210201	Тэтгэврийн даатгал	307,619,401.20	359,930,369.52
210202	Тэтгэмжийн даатгал	35,203,315.78	42,185,573.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,441,805.84	23,057,701.58
210204	Ажилгүйдлийн даатгал	15,810,928.77	18,897,358.05
210205	Эрүүл мэндийн даатгал	65,338,869.40	76,489,068.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	287,512,010.22	341,933,663.96
210301	Гэрэл, цахилгаан	66,702,776.90	98,421,000.00
210302	Түлш, халаалт	155,244,152.32	175,494,427.96
210303	Цэвэр, бохир ус	65,565,081.00	68,018,236.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,121,863.84	43,212,303.00
210401	Бичиг хэрэг	5,686,100.00	-
210402	Тээвэр, шатахуун	14,619,035.00	20,850,027.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,914,845.50	7,309,744.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,705,722.70	4,124,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,196,160.64	10,928,532.00
2105	Нормативт зардал	143,619,832.80	215,177,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,314,670.00	-
210502	Хоол, хүнс	142,305,162.80	215,177,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	81,260,492.00	75,549,226.70
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	49,269,512.00	13,670,200.00
210604	Урсгал засвар	31,990,980.00	61,879,026.70
2107	Томилолт, зочны зардал	10,501,000.00	12,147,000.00
210702	Дотоод албан томилолт	10,501,000.00	12,147,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	85,212,382.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	85,212,382.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,666,878,843.27	1,222,094,413.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	610,980,873.99	388,155,645.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	239,035,611.01	166,805,487.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	816,862,358.27	667,133,280.75

Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	467,578,571.25	299,450,277.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	362,027,881.47	282,794,873.54
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	173,217,831.47	77,947,889.40
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	180,752,000.00	146,390,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,058,050.00	58,456,984.14
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	16,244,767.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	16,244,767.85
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	105,550,689.78	410,636.04
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	105,550,689.78	410,636.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	12,680,634,809.93	(322,395,872.83)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	12,680,634,809.93	(322,395,872.83)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	6,599,253,323.34	6,649,488,670.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	333,913,321.13	-
120	Нийтлэг татварын бус орлого	333,913,321.13	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	333,913,321.13	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	133,380,585.46	-
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	200,532,735.67	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,265,340,002.21	6,649,488,670.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,587,786,600.00	6,073,979,478.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,587,786,600.00	6,073,979,478.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	284,490,702.21	233,164,892.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	166,198,699.36	233,164,892.00
131107	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	118,292,002.85	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	393,062,700.00	342,344,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	393,062,700.00	342,344,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,888,821,009.90	6,522,086,065.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,888,821,009.90	6,522,086,065.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,421,242,438.65	6,222,635,787.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,609,036,457.39	4,211,270,298.16
210101	Үндсэн цалин	2,194,320,549.00	2,398,496,449.00
210102	Нэмэгдэл	1,035,854,678.69	1,426,118,748.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	155,642,199.00	158,620,324.00
210104	Урамшуулал	223,219,030.70	228,034,777.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	442,358,189.60	520,560,071.28
210201	Тэтгэврийн даатгал	307,563,269.81	359,930,369.52
210202	Тэтгэмжийн даатгал	35,203,315.78	42,185,573.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,441,805.84	23,057,701.58
210204	Ажилгүйдлийн даатгал	15,810,928.77	18,897,358.05
210205	Эрүүл мэндийн даатгал	65,338,869.40	76,489,068.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	287,512,010.22	341,933,663.96
210301	Гэрэл, цахилгаан	66,702,776.90	98,421,000.00
210302	Түлш, халаалт	155,244,152.32	175,494,427.96
210303	Цэвэр, бохир ус	65,565,081.00	68,018,236.00
2105	Нормативт зардал	142,305,162.80	215,177,500.00
210502	Хоол, хүнс	142,305,162.80	215,177,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	81,260,502.00	139,014,353.53
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	49,269,522.00	36,766,500.00
210604	Урсгал засвар	31,990,980.00	102,247,853.53
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	85,212,382.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	85,212,382.00

Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	858,770,116.64	709,467,518.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	591,251,693.13	456,085,386.82
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	267,518,423.51	253,382,131.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	467,578,571.25	299,450,277.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	362,027,881.47	282,794,873.54
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	173,217,831.47	77,947,889.40
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	180,752,000.00	146,390,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,058,050.00	58,456,984.14
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	16,244,767.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	16,244,767.85
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	105,550,689.78	410,636.04
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	105,550,689.78	410,636.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	710,432,313.44	127,402,604.92
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	49,855,060.00	96,024,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49,855,060.00	96,024,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	49,855,060.00	96,024,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	49,855,060.00	96,024,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(49,855,060.00)	(96,024,400.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	660,577,253.44	31,378,204.92
9	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	660,577,253.44
10	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	660,577,253.44	691,955,458.36

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,244,182,833.00	-	(9,123,790,915.15)	-	(3,879,608,082.15)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,244,182,833.00	-	(9,123,790,915.15)	-	(3,879,608,082.15)
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	5,244,182,833.00	-	12,680,634,809.93	-	17,924,817,642.93
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,244,182,833.00	3,879,608,082.15	3,556,843,894.78	-	12,680,634,809.93
9	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,244,182,833.00	3,879,608,082.15	3,556,843,894.78	-	12,680,634,809.93
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(2,725,000.00)	-	(2,725,000.00)
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,244,182,833.00	3,879,608,082.15	3,554,118,894.78	-	12,677,909,809.93
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	(322,395,872.83)	-	(322,395,872.83)
17	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,244,182,833.00	3,879,608,082.15	3,231,723,021.95	-	12,355,513,937.10

Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	ТАЙЛАНТ ОНЫ	
		ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	660,577,253.44
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,083,491,000.00	6,649,488,670.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,073,979,500.00	6,073,979,478.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	6,073,979,500.00	6,073,979,478.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	536,950,800.00	342,344,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	381,715,300.00	342,344,300.00
132002	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	155,235,500.00	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	472,560,700.00	233,164,892.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	426,980,700.00	233,164,892.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,580,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,083,491,000.00	6,618,110,465.08
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	7,083,491,000.00	6,618,110,465.08
210	Бараа, үйлчилгээний зардал	6,754,898,900.00	6,318,660,187.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,321,327,200.00	4,211,270,298.16
210101	Үндсэн цалин	2,455,282,200.00	2,398,496,449.00
210102	Нэмэгдэл	1,705,699,400.00	1,426,118,748.16
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	160,345,600.00	158,620,324.00
210104	Урамшуулал	-	228,034,777.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	545,530,000.00	520,560,071.28
210201	Тэтгэврийн даатгал	370,960,300.00	359,930,369.52
210202	Тэтгэмжийн даатгал	43,642,300.00	42,185,573.90
210203	ҮОМШӨ ний даатгал	21,821,300.00	23,057,701.58
210204	Ажилгүйдлийн даатгал	21,821,300.00	18,897,358.05
210205	Эрүүл мэндийн даатгал	87,284,800.00	76,489,068.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	381,715,300.00	341,933,663.96
210301	Гэрэл цахилгаан	98,421,000.00	98,421,000.00
210302	Түлш, халаалт	177,994,300.00	175,494,427.96
210303	Цэвэр, бохир ус	100,300,000.00	68,018,236.00
210304	Байрны түрээс	5,000,000.00	-
2105	Нормативт зардал	296,010,500.00	215,177,500.00
210502	Хоол, хүнс	296,010,500.00	215,177,500.00
2106	Эд хогшил худалдан авах	139,266,500.00	139,014,353.53
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	36,766,500.00	36,766,500.00
210604	Урсгал засвар	102,500,000.00	102,247,853.53
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	158,890,700.00	85,212,382.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	158,890,700.00	85,212,382.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	912,158,700.00	805,491,918.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	557,448,300.00	459,330,186.82
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	354,710,400.00	346,161,731.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	328,592,100.00	299,450,277.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	328,592,100.00	282,794,873.54
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	77,975,000.00	77,947,889.40
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	181,225,000.00	146,390,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	69,392,100.00	58,456,984.14
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	16,244,767.85
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	16,244,767.85
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		410,636.04
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	660,577,253.44
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	691,955,458.36
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	142.00	138.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	106.00	102.00
620003	Үйлчлэх ажилтан	35.00	35.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	1,276.00	1,250.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,481.0 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс, 7,842.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14,639.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 1 зөвлөмж хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

Боловсролын сайдын 2025 оны 1/3492 дугаар албан бичгийг үндэслэн Дорнод аймаг дахь Политехник коллежийн захирлын Б/102 дугаар тушаалаар "2024 оны санхүүгийн жилийн үйл ажиллагаанд аудит хийж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж өөрчлөлтгүй санал, дүгнэлт авсан тул санхүүгийн албаны албан тушаалтнуудад урамшуулал олгосугай" гэсний дагуу нэр бүхий 6 албан хаагчдад тус бүр 1 сарын үндсэн цалинтай нь тэнцэх нийт 7,842.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" гэсний 15.1.3-т Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол болох "Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ыг тус тус зөрчиж урамшууллын хэмжээг давхардуулан олгосон байна. Тус зөрчилд өмнөх оны аудитаар таслан зогсоох албан шаардлага өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй тул давхардуулан олгосон урамшуулалд төлбөрийн акт тогтоосон. Дараагийн аудитаар зөрчлийг дахин давтах тохиолдолд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх үндэслэл болно.

3.2 Албан шаардлага

Тус коллежийн нэр бүхий 10 багшид Мэргэжлийн болон техник боловсрол, сургалтын тухай хуулийн 16.1.2 дахь заалтын дагуу 5 жил тутамд олгодог мөнгөн тэтгэмжийг олгохдоо хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: 6.3.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого" гэж заасан бол мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна: 7.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар мэдээлбэл зохих 170 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв оруулсан байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Өмнөх оны санхүүгийн жилийн тайланд өгсөн дүгнэлтийг үндэслэн санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогчийг 2 сарын, ахлах нягтлан бодогчийг 1.5 сарын, туслах нягтлан бодогчийг 1.5 сарын, 3 нярвыг тус бүр 1 сарын үндсэн цалингаар урамшуулсан байна.	1	7,842.0	1	7,842.0									
Тус коллежийн нэр бүхий 10 багшид Мэргэжлийн болон техник боловсрол, сургалтын тухай хуулийн 16.1.2 дахь заалтын дагуу 5 жил тутамд олгодог мөнгөн тэтгэмжийг олгохдоо хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй байна.	1	14,639.0			1	14,639.0							
Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 170 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож илгээсэн байна.	1							1					
Нийт дүн	3	22,481.0	1	7,842.0	1	14,639.0	1	0	-	-	-	-	-